

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН 2011 ОНЫ ШҮҮН  
ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ДҮНГИЙН  
ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2012 оны 01 дүгээр  
сарын 16-ний өдөр

Улаанбаатар  
хот

**Нэг. Эрүүгийн шүүн таслах ажиллагааны талаар**

Анхан шатны шүүхүүд 2011 онд 10517 хүнд холбогдох 6776 эрүүгийн хэрэг хүлээн авч, 825 хүнд холбогдох 448 эрүүгийн хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр буцааж, 25 хүнд холбогдох 13 хэргийг харъяаллын дагуу шилжүүлж, шүүгдэгч, хохирогч эвлэрснээр 453 хүнд, цагаатгах тогтоолоор 302 хүнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, **8210** хүнд холбогдох **5877** хэргийг таслан шийдвэрлэж, 702 холбогдогчтой 438 хэргийн үлдэгдэлтэй байна.

Өнгөрсөн оноос шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 7,6 хувиар, ял шийтгүүлэгчид 12,6 хувиар өсчээ.

Анхан шатны шүүхээр 2011 онд таслан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо, ял шийтгүүлэгчдийг өмнөх онтой нь харьцуулж үзвэл:

Д/д	Шүүх	Эрүүгийн хэргийн тоо				Ял шийтгүүлэгчдийн тоо			
		Бүтэн жилд		Өсөлт, бууралт		Бүтэн жилд		Өсөлт, бууралт	
		2010 он	2011 он	тоо	хувь	2010 он	2011 он	тоо	хувь
1	Архангай	87	108	21	24.1	130	204	74	56.9
2	Баян-Өлгий	62	88	26	41.9	79	132	53	67.1
3	Баянхонгор	154	170	16	10.4	188	199	11	5.9
4	Булган	74	124	50	67.6	102	164	62	60.8
5	Говь-Алтай	64	84	20	31.3	80	118	38	47.5
6	Говьсүмбэр	46	33	-13	-28.3	46	48	2	4.3
7	Дархан-Уул	247	278	31	12.6	339	412	73	21.5
8	Дорнод	125	120	-5	-4.0	157	162	5	3.2
9	Дорноговь	232	179	-53	-22.8	298	235	-63	-21.1
10	Дундговь	68	80	12	17.6	78	83	5	6.4
11	Завхан	68	52	-16	-23.5	81	63	-18	-22.2
12	Орхон	150	161	11	7.3	236	267	31	13.1
13	Өвөрхангай	164	182	18	11.0	221	266	45	20.4
14	Өмнөговь	117	128	11	9.4	160	172	12	7.5
15	Сүхбаатар	114	110	-4	-3.5	122	102	-20	-16.4
16	Сэлэнгэ	284	279	-5	-1.8	389	409	20	5.1
17	Төв	170	213	43	25.3	215	291	76	35.3
18	Увс	143	125	-18	-12.6	195	200	5	2.6
19	Ховд	104	114	10	9.6	147	151	4	2.7
20	Хөвсгөл	111	185	74	66.7	138	250	112	81.2
21	Хэнтий	155	265	110	71.0	191	338	147	77.0
22	Нийслэл	2721	2799	78	2.9	3700	3944	244	6.6
	<b>Дүн</b>	<b>5460</b>	<b>5877</b>	<b>417</b>	<b>7.6</b>	<b>7292</b>	<b>8210</b>	<b>918</b>	<b>12.6</b>

байдалтай байна.

Таслан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг Сэлэнгэ, Сүхбаатар, Дорнод, Увс, Дорноговь, Завхан, Говьсүмбэр аймагт 1,8 – 28,3 хувиар буурч, Нийслэл, Орхон, Өмнөговь, Ховд, Баянхонгор, Өвөрхангай, Дархан-Уул, Дундговь, Архангай, Төв, Говь-Алтай, Баян-Өлгий, Хөвсгөл, Булган, Хэнтий аймагт 2,9 – 71,0 хувиар нэмэгджээ.

Ял шийтгүүлэгчид Сүхбаатар, Дорноговь, Завхан аймагт 16,4 – 22,2 хувиар буурч, Увс, Ховд, Дорнод, Говьсүмбэр, Сэлэнгэ, Баянхонгор, Дундговь, Нийслэл, Өмнөговь, Орхон, Өвөрхангай, Дархан-Уул, Төв, Говь-Алтай, Архангай, Булган, Баян-Өлгий, Хэнтий, Хөвсгөл аймагт 2,6 – 81,2 хувиар өссөн байна.

Анхаарал татаж байгаа эрүүгийн хэргийг авч үзвэл:

Д/д	Хэргийн төрөл	Хэргийн тоо				Ял шийтгүүлэгчид			
		Бүтэн жилд		Өсөлт, бууралт		Бүтэн жилд		Өсөлт, бууралт	
		2010 он	2011 он	тоо	хувь	2010 он	2011 он	тоо	хувь
1	Хүнийг санаатай алах	244	242	-2	-0.8	280	269	-11	-3.9
2	Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах	330	290	-40	-12.1	344	294	-50	-14.5
3	Бусдын эд хөрөнгийг хулгайлах	1235	1282	47	3.8	1903	2227	324	17.0
4	Танхайрах	807	863	56	6.9	1202	1327	125	10.4
5	Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх	250	222	-28	-11.2	488	437	-51	-10.5
6	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	751	865	114	15.2	770	888	118	15.3
7	Албан тушаалын гэмт хэрэг	16	22	6	37.5	27	33	6	22.2
8	Эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх	57	35	-22	-38.6	83	54	-29	-34.9

байдалтай байна.

Эдгээр төрлийн гэмт хэрэг таслан шийдвэрлэсэн нийт хэргийн 65,0 хувь, ял шийтгүүлэгчдийн 67,3 хувийг эзэлж байгаа бол бусдын эд хөрөнгийг хулгайлах, танхайрах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн нийлбэр нь нийт хэргийн 51,2, ял шийтгүүлэгчдийн 54,1 хувийг эзэлж байна.

Өнгөрсөн оныхоос бусдыг санаатай алсан гэмт хэрэг 0,8, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг 11,2, бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах гэмт хэрэг 12,1, эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэг 38,6 хувиар буурсан бол, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 3,8, танхайрах гэмт хэрэг 6,9, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 15,2, албан тушаалын гэмт хэрэг 37,5 хувиар тус тус өсчээ.

Ял шийтгүүлэгчдийн байдлыг авч үзвэл:

Д/д	Үзүүлэлт	Бүтэн жил		Өсөлт, бууралт	
		2010 он	2011 он	Тоо	Хувиар
Ял шийтгүүлэгчид. Үүнээс:	Насанд хүрээгүй этгээд	451	542	91	20.2
	Эмэгтэйчүүд	612	724	112	18.3
	Гадаадын харъяат	30	27	-3	-10.0
	Урьд ял шийтгүүлсэн	1645	1460	-185	-11.2
	Гэмт хэрэг бүлэглэж үйлдсэн	1407	1465	58	4.1
	Согтуугаар гэмт хэрэг үйлдсэн	1512	1704	192	12.7
	Ажил, сургуульгүй хүмүүс	4881	5493	612	12.5

байдалтай байна.

Гэмт хэргийн улмаас нийтдээ 13 тэрбум 855 сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирч, 589 хүний амь хохирч, 2562 хүний биед (хүнд, хүндэвтэр, хөнгөн) гэмтэл учирчээ.

Шүүхээс оногдуулсан ял шийтгэлийн байдлыг авч үзвэл:

Д/д	Төрөл	Бүтэн жил		Нийт ялын дотор эзлэх хувь	
		2010 он	2011 он	2010 он	2011 он
<b>Нийт ял шийтгүүлэгчид</b>		<b>7292</b>	<b>8210</b>		
1	<i>Хорих ялаар бүгд: Үүнээс</i>	<b>5537</b>	<b>6357</b>	<b>75.9</b>	<b>77.4</b>
	а/ Хорих ялыг биечлэн эдлүүлсэн	2543	2781		
	б/ Тэнссэн	2444	3084		
	в/ Эрүүгийн хуулийн 62, 63-р зүйлээр шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан Үүнээс:	434	442		
	а/Насанд хүрээгүй этгээд	353	362		
	б/Жирэмсэн эмэгтэй 3 хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэг	81	80		
	г/ Өршөөл үзүүлсэн	116	50		
2	<i>Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн: Үүнээс</i>	<b>1668</b>	<b>1770</b>	<b>22.9</b>	<b>21.6</b>
	а/ Торгох ял	281	271		
	б/ Албадан ажил хийлгэх ял	376	476		
	в/ Баривчлах ял	1011	1023		
3	<i>Бусад ял</i>	<b>19</b>	<b>10</b>	<b>0.3</b>	<b>0.1</b>
4	<i>Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ</i>	<b>68</b>	<b>73</b>	<b>0.9</b>	<b>0.9</b>

байдалтай байна.

Ял шийтгүүлэгчдийн 77,4 хувьд хорих, 5,8 хувьд албадан ажил хийлгэх, 12,5 хувьд баривчлах, 0,1 хувьд бусад ял оногдуулж, насанд хүрээгүй 73 этгээдэд (0,9 хувь) хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг авчээ. Мөн 3,3 хувь буюу 271 хүнийг 2 тэрбум 483 сая төгрөгөөр торгох ял оногдуулжээ.

2781 хүнд оногдуулсан хорих ялыг биечлэн эдлүүлсэн нь хорих ял шийтгүүлэгчдийн 43,7 хувь нь болж байна.

Хорих ялыг биечлэн эдлүүлсэн ба баривчлах ялаар шийтгүүлсэн хүн 3804 байгаа нь нийт ял шийтгүүлэгчдийн 46,3 хувийг эзэлж байна.

Шүүх эд хөрөнгө хураах нэмэгдэл ялыг 402 хүнд хэрэглэж 103,1 сая төгрөг гаргуулсны дээр, тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах ялыг 628 хүнд нэмэгдэл ялын чанартайгаар оногдуулжээ.

Шүүх хорих ял биечлэн эдлүүлсэн 2781 хүний 70,1 хувийг жирийн, 28,0 хувийг чанга, 1,6 хувийг онцгой, 0,3 хувийг гяндангийн дэглэмд ял эдлүүлэхээр тогтоожээ.

Аймаг, нийслэлийн шүүхүүд давж заалдах журмаар эрүүгийн 2159 хэрэг хүлээн авснаас 2032 хэргийг хянан шийдвэрлэж, 1080 буюу 53,1 хувьд нь захирамж, тогтоолыг хэвээр үлдээж, 444 буюу 21,9 хувьд нь захирамж, тогтоолд өөрчлөлт оруулж, 508 буюу 25,0 хувьд нь захирамж, тогтоолыг хүчингүй болгожээ. Оны эцэст 94 хэргийн үлдэгдэлтэй гарав. 33 хэргийн хувьд эрх бүхий этгээд гаргасан гомдол, эсэргүүцлээсээ татгалзан буцаан авчээ.

Үзүүлэлт	Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь		
	2010 он	2011 он	2010 он	2011 он	зөрүү +/-,-/-
Хянан шийдвэрлэсэн бүгд	2016	2032			
Хэвээр үлдээсэн	1037	1080	51,4	53,1	+1,7
Өөрчлөлт оруулсан	476	444	23,6	21,9	-1,7
Хүчингүй болгосон	503	508	25,0	25,0	-
Үлдэгдэл	69	94			

Давж заалдах шатны шүүх 952 тогтоолыг өөрчилж, хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 46,8 хувийг эзэлж байна.

Хяналтын шатны журмаар эрүүгийн 822 хэрэг хүлээн авснаас 704 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсний 259 нь прокурорын дүгнэлтээр шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлтийг шийдвэрлэсэн хэрэг байна. Үүний 248 нь цагаатгалын хэрэг. Мөн 704 хэргийг хянаж, хариу өгсөн ба оны эцэст 13 хэргийн үлдэгдэлтэй гарав. Хяналтын шатны шүүхээр хянан хэлэлцэгдсэн эрүүгийн хэргийн шийтгэх тогтоол, магадлалын 252 буюу 35,8 хувийг хэвээр үлдээж, 90 буюу 12,8 хувийг өөрчилж, 362 буюу 51,4 хувийг хүчингүй болгожээ.

		Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь		
		2010 он	2011 он	2010 он	2011 он	зөрүү /+/, -/
Хүлээн авсан хэрэг		<b>726</b>	<b>822</b>			
Хянаад хариу өгсөн хэрэг		141	105			
Нийт шийдвэрлэсэн хэрэг Үүнээс:		<b>551</b>	<b>704</b>			
Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хянан шийдвэрлэсэн		13	3			
Хяналтын шатын шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэрэг		331	701			
Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлтийг шийдвэрлэсэн		207	259			
Үүнээс:	Хэвээр үлдээсэн	208	252	37,7	35,8	-1,9
	Өөрчлөлт оруулсан	50	90	9,1	12,8	+3,7
	Хүчингүй болгосон	293	362	53,2	51,4	-1,8
Үлдэгдэл		34	13			

Хяналтын шатны шүүх 452 тогтоол, магадлалыг өөрчилж, хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 64,2 хувийг эзэлж байна.

### Хоёр. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар

Анхан шатны шүүхүүд 42538 нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авч, 8650 нэхэмжлэлийг хуульд заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзах, буцаах, харъяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлэх зэрэг ажиллагааг хийж, бүгд **30368** хэрэг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 5419 хэргээр буюу 15,1 хувиар буурсан байна. Оны эцэст 3520 хэргийн үлдэгдэлтэй гарав.

Хянан шийдвэрлэсэн нийт 30368 хэргийн 10920 буюу 36,0 хувийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасан хялбаршуулсан журмаар, 18769 буюу 61,8 хувийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцжээ.

Анхан шатны шүүхээр 2011 онд хянан шийдвэрлэсэн иргэний хэргийг урьд онтой харьцуулж үзвэл:

Д/д	Шүүх	Бүтэн жилд		өсөлт, бууралт	
		2010 он	2011 он	тоо	хувь
1	Архангай	843	636	-207	-24.6
2	Баян-Өлгий	935	671	-264	-28.2
3	Баянхонгор	853	595	-258	-30.2
4	Булган	731	507	-224	-30.6
5	Говь-Алтай	678	319	-359	-52.9
6	Говьсүмбэр	292	153	-139	-47.6
7	Дархан-Уул	2062	1634	-428	-20.8
8	Дорнод	1056	889	-167	-15.8
9	Дорноговь	887	464	-423	-47.7
10	Дундговь	566	421	-145	-25.6
11	Завхан	924	665	-259	-28.0
12	Орхон	1419	1196	-223	-15.7
13	Өвөрхангай	1768	1066	-702	-39.7
14	Өмнөговь	553	452	-101	-18.3
15	Сүхбаатар	689	348	-341	-49.5
16	Сэлэнгэ	1520	1426	-94	-6.2
17	Төв	1404	1494	90	6.4
18	Увс	686	687	1	0.1
19	Ховд	1599	1172	-427	-26.7
20	Хөвсгөл	1925	1423	-502	-26.1
21	Хэнтий	974	782	-192	-19.7
22	Нийслэл	13423	13368	-55	-0.4
	<b>Дүн</b>	<b>35787</b>	<b>30368</b>	<b>-5419</b>	<b>-15.1</b>

байдалтай байна.

Хянан шийдвэрлэсэн иргэний хэрэг Увс, Төв аймагт 0,1 – 6,4 хувиар нэмэгджээ. Харин Нийслэл, Сэлэнгэ, Орхон, Дорнод, Өмнөговь, Хэнтий, Дархан-Уул, Архангай, Дундговь, Хөвсгөл, Ховд, Завхан, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Өвөрхангай, Говьсүмбэр, Дорноговь, Сүхбаатар, Говь-Алтай аймагт 0,4 – 52,9 хувиар буурчээ.

Хянан шийдвэрлэсэн иргэний хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл:

төрөл	Бүтэн жилд		Нийт хэрэгт эзлэх хувь		Зөрүү /+,/-/
	2010 он	2011 он	2010 он	2011 он	
<b>Нийт иргэний хэрэг</b>	<b>35787</b>	<b>30368</b>			
Иргэний эрх зүйн маргаан	14834	11568	41,5	38,1	-3,4
Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар	12159	11152	34,0	36,7	+2,7
Гэр бүлийн эрх зүйн маргаан	4732	4449	13,2	14,7	+1,5
Хөдөлмөрийн эрх зүйн маргаан	978	897	2,7	2,9	+0,2
Бусад эрх зүйн маргаан: Үүнээс:	3084	2302	8,6	7,6	-1,0
Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиар	33	17			
Дампуурлын тухай хуулиар	1	7			
Компанийн тухай хуулиар	11	24			
Нийгмийн даатгалын багц хуулиар	254	128			
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар	220	210			
Татварын ерөнхий хуулиар	383	283			
Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуулиар	4	5			
Төрийн албаны тухай хуулиар	9	6			
Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулиар	85	70			
Бусад хуулиар	2084	1552			

Нийт хэрэгт иргэний эрх зүйн маргаан 38,1, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн маргаан 36,7, гэр бүлийн эрх зүйн маргаан 14,7, хөдөлмөрийн эрх зүйн маргаан 2,9 хувийг тус тус эзэлж байна.

Аймаг, нийслэлийн шүүхүүд давж заалдах журмаар 1925 хэрэг хүлээн авснаас 1830 хэргийг хянан шийдвэрлэж, үүнээс 989 буюу 54,0 хувьд нь шийдвэрийг хэвээр үлдээж, 448 буюу 24,5 хувьд нь шийдвэрт өөрчлөлт оруулж, 393 буюу 21,5 хувьд шийдвэрийг хүчингүй болгож, оны эцэст 53 хэргийн үлдэгдэлтэй гарав. 11 хэрэг нь давж заалдах гомдлыг хэлэлцэхээс татгалзаж, 31 хэргийн хувьд эрх бүхий этгээд гаргасан гомдол, эсэргүүцлээсээ татгалзан буцаан авчээ.

Үзүүлэлт	Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь		
	2010 он	2011 он	2010 он	2011 он	зөрүү /+/,/-/
Хянан шийдвэрлэсэн бүгд	<b>2102</b>	<b>1830</b>			
Хэвээр үлдээсэн	1134	989	54,0	54,0	-
Өөрчлөлт оруулсан	543	448	25,8	24,5	-1,3
Хүчингүй болгосон	425	393	20,2	21,5	+1,3
Үлдэгдэл	98	53			

Давж заалдах шатны шүүх 841 шийдвэрийг өөрчилж, хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 46,0 хувийг эзэлж байна.

Хяналтын шатны журмаар иргэний 1135 хэрэг хүлээн авч, 228-г хянан хариу өгч, 861 хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцсэн байна. Үүнээс шийдвэр, магадлалын 579 буюу 67,2 хувийг хэвээр үлдээж, 173 буюу 20,1 хувийг өөрчилж, 109 буюу 12,7 хувийг нь хүчингүй болгож, 46 хэргийн үлдэгдэлтэй гарав. Хянан шийдвэрлэсэн нийт 861 хэргээс 1 хэргийг Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар, 38 хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан шийдвэрлэжээ.

	Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь			
	2010 он	2011 он	2010 он	2011 он	зөрүү /+/,/-/	
Хүлээн авсан хэрэг	<b>1334</b>	<b>1135</b>				
Хянаад хариу өгсөн хэрэг	257	228				
Нийт шийдвэрлэсэн хэрэг Үүнээс:	<b>1025</b>	<b>861</b>				
Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хянан шийдвэрлэсэн	3	1				
Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэрэг	984	822				
Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлтийг шийдвэрлэсэн	38	38				
Үүнээс	Хэвээр үлдээсэн	615	579	60,0	67,2	+7,2
	Өөрчлөлт оруулсан	248	173	24,2	20,1	-4,1
	Хүчингүй болгосон	162	109	15,8	12,7	-3,1
Үлдэгдэл	52	46				

Хяналтын шатны шүүх 282 шийдвэр, магадлалыг өөрчилж хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 32,7 хувийг эзэлж байна.



## Гурав. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар

Захиргааны хэргийн шүүхүүд 2011 онд 1556 нэхэмжлэл, гомдол хүлээн авч, 403 нэхэмжлэлийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэлээр харъяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлэх буюу захиргааны журмаар урьдчилан шийдвэрлүүлэх шаардлагыг хангуулахаар нэхэмжлэгчид нь буцааж, **891** хэргийг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 140 хэргээр буюу 13,6 хувиар буурчээ.

Оны эцэст 262 хэргийн үлдэгдэлтэй гарсны дотор хуульд заасан үндэслэлээр 54 хэргийн хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, 42 хэргийн шүүх хуралдааныг хойшлуулж, 166 хэрэгт хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байна.

2011 онд хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийг шүүх тус бүрээр үзүүлбэл:

Д/д	Шүүх	Бүтэн жилд		Өсөлт, бууралт	
		2010 он	2011 он	тоо	хувь
1	Архангай	19	18	-1	-5.3
2	Баян-Өлгий	66	46	-20	-30.3
3	Баянхонгор	21	12	-9	-42.9
4	Булган	29	18	-11	-37.9
5	Говь-Алтай	11	5	-6	-54.5
6	Говьсүмбэр	9	5	-4	-44.4
7	Дархан-Уул	29	27	-2	-6.9
8	Дорнод	21	14	-7	-33.3
9	Дорноговь	18	24	6	33.3
10	Дундговь	12	8	-4	-33.3
11	Завхан	12	1	-11	-91.7
12	Орхон	39	38	-1	-2.6
13	Өвөрхангай	38	22	-16	-42.1
14	Өмнөговь	11	11	0	0.0
15	Сүхбаатар	24	21	-3	-12.5
16	Сэлэнгэ	21	8	-13	-61.9
17	Төв	31	11	-20	-64.5
18	Увс	22	32	10	45.5
19	Ховд	8	10	2	25.0
20	Хөвсгөл	34	19	-15	-44.1
21	Хэнтий	24	8	-16	-66.7
22	Нийслэл	532	533	1	0.2
	<b>Дүн</b>	<b>1031</b>	<b>891</b>	<b>-140</b>	<b>-13.6</b>

байдалтай байна.

Хянан шийдвэрлэсэн захиргааны хэрэг Нийслэл, Ховд, Дорноговь, Увс аймагт 0,2 – 45,5 хувиар нэмэгдэж, Орхон, Архангай, Дархан-Уул, Сүхбаатар, Баян-Өлгий, Дундговь, Дорнод, Булган, Өвөрхангай, Баянхонгор, Хөвсгөл, Говьсүмбэр, Говь-Алтай, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Завхан аймагт 2,6 – 91,7 хувиар буурчээ. Харин Өмнөговь аймаг өмнөх оны мөн үетэй адил байна.

Хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийг маргааны төрлөөр авч үзвэл,

Маргааны төрөл	Бүтэн жилд		Нийт хэрэгт эзлэх хувь	
	2010 он	2011 он	2010 он	2011 он
<b>Нийт захиргааны хэрэг</b>	<b>1031</b>	<b>891</b>		
Сонгуультай холбоотой маргаан	38	10	3,7	1,1
Төрийн албаны тухай хуулиар	214	139	20,8	15,6
Төрийн болон орон нутгийн өмчийн тухай маргаан	9	11	0,9	1,2
Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлтэй холбоотой маргаан	69	83	6,7	9,3
Газрын маргаан	214	228	20,8	25,6
Ашигт малтмалтай холбоотой маргаан	76	86	7,4	9,7
Татварын маргаан	116	76	11,2	8,5
Тендерийн маргаан	35	38	3,3	4,3
Бусад маргаан	260	220	25,2	24,7

байдалтай байна.

Давж заалдах шатны журмаар захиргааны 551 хэрэг хүлээн авч, 492 хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцсэнээс, 8 хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан шийдвэрлэжээ. Хянан хэлэлцсэн нийт хэргийн 53,9 хувь буюу 265 шийдвэр, захирамжийг хэвээр үлдээж, 13,4 хувь буюу 66 шийдвэрт өөрчлөлт оруулж, 32,7 хувь буюу 161 шийдвэр захирамжийг хүчингүй болгож, оны эцэст 47 хэргийн үлдэгдэлтэй гарчээ.

Үүнээс шинээр байгуулагдсан Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх 388 хэрэг хүлээн авч, 353 хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцсэнээс, 5 хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан шийдвэрлэжээ. Хянан хэлэлцсэн нийт хэргийн 49,3 хувь буюу 174 шийдвэр, захирамжийг хэвээр үлдээж, 15,0 хувь буюу 53 шийдвэрт өөрчлөлт оруулж, 35,7 хувь буюу 126 шийдвэр захирамжийг хүчингүй болгож, оны эцэст 26 хэргийн үлдэгдэлтэй гарчээ.

Үзүүлэлт	Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь			
	2010 он	2011 он	2010 он	2011 он	зөрүү /+/, -/	
<b>Хүлээн авсан хэрэг</b>	<b>573</b>	<b>551</b>				
Хянаад хариу өгсөн	23	12				
Нийт шийдвэрлэсэн хэрэг Үүнээс:	<b>521</b>	<b>492</b>				
Хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэрэг	516	484				
Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянасан	5	8				
Үүнээс	Хэвээр үлдээсэн	327	265	62,8	53,9	-8,9
	Өөрчлөлт оруулсан	57	66	10,9	13,4	+2,5
	Хүчингүй болгосон	137	161	26,3	32,7	+6,4
Үлдэгдэл	29	47				

Хяналтын шатны шүүх 331 хэрэг хүлээн авснаас 240 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, 70 хэргийг хянан хариу өгч, одоо 9 хэргийн үлдэгдэлтэй байна. Хянан хэлэлцсэн 240 хэргээс 12 хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан шийдвэрлэжээ. Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан хэлэлцэгдсэн 240 хэргийн 71,2 хувь буюу 171 шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, 19,6 хувь буюу 47 шийдвэр, магадлалыг өөрчилж, 9,2 хувь буюу 22 шийдвэр, магадлалыг хүчингүй болгожээ.

Үзүүлэлт		Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь		
		2010 он	2011 он	2010 он	2011 он	зөрүү /+/,/-/
Хүлээн авсан хэрэг		<b>427</b>	<b>331</b>			
Хянаад хариу өгсөн хэрэг		83	70			
Нийт шийдвэрлэсэн хэрэг. Үүнээс:		<b>324</b>	<b>240</b>			
Хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэрэг		312	228			
Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянасан		12	12			
Үүнээс	Хэвээр үлдээсэн	217	171	67,0	71,2	+4,2
	Өөрчлөлт оруулсан	77	47	23,8	19,6	-4,2
	Хүчингүй болгосон	30	22	9,2	9,2	0
Үлдэгдэл		<b>20</b>	<b>9</b>			

Хяналтын шатны шүүх 69 шийдвэр, магадлалыг өөрчилж хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 28,7 хувийг эзэлж байна.

### **Дөрөв. Бусад асуудлаар**

Анхан шатны шүүхүүд бүгд 13452 (+1603) хүнд захиргааны арга хэмжээ авсны дотор 675 (+10) хүнийг 9,4 (+3,6) сая төгрөгөөр торгож, 12777 (+1698) хүнд баривчлах шийтгэл ногдуулжээ.

Захиргааны зөрчил гаргасан этгээд, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч буюу өмгөөлөгчийн гаргасан гомдлоор захиргааны шийтгэл ногдуулсан 203 (-2) шийтгэврийг давж заалдах журмаар хянаснаас 150 буюу 73,9 хувьд хэвээр үлдээж, 45 буюу 22,2 хувьд өөрчлөлт оруулж, 8 буюу 3,9 хувийг хүчингүй болгожээ.

Тайлангийн хугацаанд шүүхүүд ялтныг хорих ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллах тухай 1474 (+148) материалыг хянан хэлэлцэж, 36 (+24) санал дүгнэлтийг хэрэгсэхгүй болгож, 895 (+69) хоригдлыг эдлээгүй үлдсэн хорих ялаас нь тэнсэн суллаж, 32 (+24) хоригдлын хорих ялыг хорихоос өөр төрлийн хөнгөн ялаар сольж, 511 (+31) хоригдлын ял эдлэх дэглэмийг өөрчилжээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58, 59 дүгээр зүйлд заасан үндэслэлээр 715 (-138) сэжигтнийг баривчлах тухай материалыг хүлээн авч, 679 (-118) сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгож, 36 (-20) сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгохоос татгалзжээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68 дугаар зүйлд зааснаар 2222 (-169) хүнийг сэжигтнээр, 2173 (-354) хүнийг яллагдагчаар цагдан хорьж, 305 (+43) хүнд цагдан хорих зөвшөөрөл олгохоос татгалзсан байна.

Иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх явцад улсын тэмдэгтийн хураамжид 2 тэрбум 417,6 (-9,2) сая төгрөг, үүнээс анхан шатны шүүх 1 тэрбум 953 (-17,0) сая төгрөг, давж заалдах шатны шүүх 332,3 (-7,9) сая төгрөг, хяналтын шатны шүүх 132,2 (+15,6) сая төгрөгийг улс, орон нутгийн орлогод оруулахаар шийдвэрлэв. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасан үндэслэлээр анхан шатны шүүхээс 410,1 (-37,3) сая төгрөг, давж заалдах шатны шүүхээс 144,0 (-76,3) сая төгрөг, хяналтын шатны шүүхээс 92,5 (-13,9) сая төгрөгийн улсын тэмдэгтийн хураамжийг зохигчдод буцаан олгохоор шийдвэрлэсэн байна.

Анхан шатны шүүхүүд нийт 67706 (-4096) хэрэг, маргааныг шийдвэрлэсний дотор эрүүгийн 6338 (+74), иргэний 39018 (-5128), захиргааны 1294 (-93) хэрэг, 13452 (+1603) захиргааны зөрчил, ялтныг ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллах, үлдсэн ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих тухай 1474 (+148) хүсэлт, 6130 (-756) хүнд баривчлах, цагдан хорих зөвшөөрөл олгох эсэх тухай асуудал хэлэлцжээ.

Ерөнхий харъяаллын анхан шатны шүүх болох сум, сум дундын шүүхийн нэг шүүгч дунджаар 211, дүүргийн шүүхийн нэг шүүгч дунджаар 358 хэрэг маргаан хянан шийдвэрлэсэн байна.

Аймгийн Захиргааны хэргийн шүүхийн нэг шүүгч дунджаар 10, нийслэлийн захиргааны хэргийн нэг шүүгч дунджаар 101 хэрэг хянан шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүхүүд эрүүгийн 2065, иргэний 1777, захиргааны 362, захиргааны зөрчлийн 203 бүгд 4407 хэрэг хянан шийдвэрлэжээ. Аймгийн шүүхийн нэг шүүгч дунджаар 26, нийслэлийн шүүхийн нэг шүүгч дунджаар 115 хэрэг хянан шийдвэрлэсэн байна.

Хяналтын шатны шүүх буюу Улсын Дээд шүүх иргэний 861, эрүүгийн 704, захиргааны 240, давж заалдах журмаар 142 нийтдээ 1947 хэрэг хянан шийдвэрлэсэн байна. Дээд шүүхийн нэг шүүгчид дунджаар иргэний хэрэг 172, эрүүгийн хэрэг 141, захиргааны 76 хэрэг ногдож байна.

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН  
СУДАЛГААНЫ ТӨВИЙН  
ЗАХИРАЛ

Ч.НЯМСҮРЭН

ШҮҮХИЙН СТАТИСТИК,  
ТООН МЭДЭЭЛЭЛ  
ХАРИУЦСАН АХЛАХ  
МЭРГЭЖИЛТЭН

Д.ОЮУНЧИМЭГ